

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/134-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Сэлэнгэ аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа</p> <p>Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Батмөнх</p> <p>Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн: “Эн Ай Ти Эс Баланс Аудит” ХХК</p> <p>Утас: 77270808 Цахим хаяг: Nitsbalance@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4-10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.6.3 Нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15-16
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2.3өвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар



МАНДАЛ СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.БҮРЭНЖАРГАЛ ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/134-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон/
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,803,877.49	32,157,107.02
33	АВЛАГА	630,290.47	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	630,290.47	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	35,173,587.02	32,157,107.02
35100	Түүхий эд материал	31,800.00	0.00
35130	Эм боох материал	31,800.00	0.00
35400	Хангамжийн материал	35,141,787.02	32,157,107.02
35410	Бичиг хэргийн материал	1,552,950.00	0.00
35420	Аж ахуйн материал	12,011,219.02	12,011,219.02
35450	Барилгын засварын материал	174,000.00	0.00
35460	Хүнсний материал	1,257,730.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	20,145,888.00	20,145,888.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	788,419,945.70	752,782,746.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	788,419,945.70	752,782,746.18
39200	Биет хөрөнгө	571,473,362.27	535,861,162.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	520,665,518.05	520,665,518.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,885,072.48	-76,031,592.48
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	56,001,265.75	56,001,265.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,491,166.31	-45,789,472.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,501,773.20	31,620,447.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,904,711.34	-12,651,719.06
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,786,053.00	80,786,053.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,243,297.60	-18,782,338.24
39217	Ном	43,000.00	43,000.00
39300	Биет бус хөрөнгө	216,946,583.43	216,921,583.47
39301	Программ хангамж	1,625,000.00	1,625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-310,416.57	-335,416.53
39303	Бусад биет бус хөрөнгө	215,632,000.00	215,632,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	824,223,823.19	784,939,853.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	824,223,823.19	784,939,853.20
51	Засгийн газрын хувь оролцоо	824,223,823.19	784,939,853.20
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	332,071,103.00	332,071,103.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-61,427,975.46	-100,711,945.45
51210	Өмнөх үеийн үр дүн	-32,817,989.72	-61,427,975.46
51220	Тайлант үеийн үр дүн	-28,609,985.74	-39,283,969.99
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	553,580,695.65	553,580,695.65
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	824,223,823.19	784,939,853.20

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон/

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	559,817,638.52	526,225,669.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,291,500.00	977,229.70
120	Нийтлэг татварын бус орлого	5,291,500.00	977,229.70
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,291,500.00	118,674.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	858,555.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	554,526,138.52	525,248,440.24
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,291,800.00	496,333,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	526,291,800.00	496,333,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	320,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	320,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,234,338.52	28,595,240.24
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,234,338.52	28,595,240.24
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	588,427,624.26	565,509,639.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	588,427,624.26	565,509,639.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	525,972,667.95	546,450,339.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	369,416,426.00	383,692,901.37
210101	Үндсэн цалин	253,981,362.63	214,276,078.40
210102	Нэмэгдэл	93,761,191.82	147,717,200.97
210104	Урамшуулал	21,673,871.55	21,699,622.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,419,477.22	49,974,563.28
210201	Тэтгэврийн даатгал	30,559,905.22	35,543,513.66
210202	Тэтгэмжийн даатгал	5,594,077.66	3,846,038.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,650,516.00	3,043,251.57
210204	Ажилгүйдлийн даатгал	783,179.75	685,614.57
210205	Эрүүл мэндийн даатгал	7,831,798.59	6,856,144.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,234,338.52	28,072,340.24
210301	Гэрэл, цахилгаан	3,985,364.52	2,478,070.92
210302	Түлш, халаалт	21,394,496.00	24,126,792.32
210303	Цэвэр, бохир ус	2,854,478.00	1,467,477.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,330,800.00	7,291,150.00
210401	Бичиг хэрэг	353,600.00	1,751,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,000.00	487,400.00
210404	Ном, хэвлэл	0.00	5,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	4,195,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,338,200.00	851,900.00
2105	Нормативт зардал	26,368,040.00	30,290,810.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,800.00	989,555.00
210502	Хоол, хүнс	24,987,440.00	22,205,255.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,260,800.00	7,096,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,792,000.00	1,617,240.00
210604	Урсгал засвар	4,792,000.00	1,617,240.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,722,200.00	2,344,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,398,200.00	1,372,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,689,386.21	43,166,834.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,537,000.00	3,410,960.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,152,386.21	39,755,874.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,454,956.31	19,059,300.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,454,956.31	19,059,300.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,454,956.31	19,059,300.82
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-28,609,985.74	-39,283,969.99
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-28,609,985.74	-39,283,969.99

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон/

/төгсгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-61,427,975.46	824,223,823.19
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-61,427,975.46	824,223,823.19
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-61,427,975.46	824,223,823.19
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-39,283,969.99	-39,283,969.99
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	-100,711,945.45	784,939,853.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон/

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	554,526,138.52	525,248,440.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	554,526,138.52	525,248,440.24
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,291,800.00	496,333,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	526,291,800.00	496,333,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	320,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	320,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,234,338.52	28,595,240.24
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,234,338.52	28,595,240.24
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	547,276,138.52	521,248,440.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	547,276,138.52	521,248,440.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,821,182.21	502,189,139.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	369,416,426.00	383,692,901.37
210101	Үндсэн цалин	253,981,362.63	214,276,078.40
210102	Нэмэгдэл	93,761,191.82	147,717,200.97
210104	Урамшуулал	21,673,871.55	21,699,622.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,049,767.69	49,344,272.81
210201	Тэтгэврийн даатгал	31,190,195.69	34,913,223.19
210202	Тэтгэмжийн даатгал	5,594,077.66	3,846,038.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,650,516.00	3,043,251.57
210204	Ажилгүйдлийн даатгал	783,179.75	685,614.57
210205	Эрүүл мэндийн даатгал	7,831,798.59	6,856,144.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,234,338.52	28,072,340.24
210301	Гэрэл, цахилгаан	3,985,364.52	2,478,070.92
210302	Түлш, халаалт	21,394,496.00	24,126,792.32
210303	Цэвэр, бохир ус	2,854,478.00	1,467,477.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,330,800.00	5,845,000.00
210401	Бичиг хэрэг	353,600.00	198,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,000.00	487,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,100,000.00	4,240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,338,200.00	918,700.00
2105	Нормативт зардал	24,695,850.00	28,275,725.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	119,800.00	104,200.00
210502	Хоол, хүнс	23,315,250.00	21,075,525.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,260,800.00	7,096,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,792,000.00	1,317,400.00
210604	Урсгал засвар	4,792,000.00	1,317,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,722,200.00	2,244,500.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,398,200.00	1,272,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	972,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,579,800.00	3,397,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,579,800.00	3,397,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,454,956.31	19,059,300.82
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,454,956.31	19,059,300.82
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	62,454,956.31	19,059,300.82
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,250,000.00	4,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,250,000.00	4,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,250,000.00	4,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,250,000.00	4,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,250,000.00	4,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,250,000.00	-4,000,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон/

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	533,811,800.00	505,869,139.42	27,942,660.58	94.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,811,800.00	505,869,139.42	27,942,660.58	94.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	533,811,800.00	505,869,139.42	27,942,660.58	94.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	385,023,600.00	383,692,901.37	1,330,698.63	99.6
210101	Үндсэн цалин	277,451,000.00	214,276,078.40	63,174,921.60	77.2
210102	Нэмэгдэл	85,854,800.00	147,717,200.97	-61,862,400.97	172.0
210104	Урамшуулал	21,717,800.00	21,699,622.00	18,178.00	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,343,900.00	49,344,272.81	999,627.16	98.0
210201	Тэтгэврийн даатгал	34,943,000.00	34,913,223.19	29,776.81	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,850,200.00	3,846,038.65	4,161.35	99.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,080,200.00	3,043,251.57	36,948.43	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	770,000.00	685,614.57	84,385.43	89.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,700,500.00	6,856,144.83	844,355.17	89.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,955,700.00	28,072,340.24	8,883,359.76	75.9
210301	Гэрэл, цахилгаан	5,346,000.00	2,478,070.92	2,867,929.08	46.3

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	26,511,700.00	24,126,792.32	2,384,907.68	91.0
210303	Цэвэр, бохир ус	5,098,000.00	1,467,477.00	3,630,523.00	28.7
2104	Хангамж, бараа материалын зардал	5,581,600.00	5,525,000.00	56,600.00	98.9
210401	Бичиг хэрэг	198,900.00	198,900.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	539,000.00	487,400.00	51,600.00	90.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,925,000.00	3,920,000.00	5000.00	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	918,700.00	918,700.00	918,700.00	100.0
2105	Нормативт зардал	44,457,200.00	28,275,725.00	16,181,475.00	63.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,200.00	104,200.00	104,200.00	100.0
210502	Хоол, хүнс	37,257,000.00	21,075,525.00	16,181,475.00	56.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,096,000.00	7,096,000.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,317,400.00	5,317,400.00	0.00	100.0
210602	Тавилга	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,317,400.00	1,317,400.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	166,900.00	0.00	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,568,500.00	2,244,500.00	324,000.00	87.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,272,500.00	1,272,500.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,296,000.00	972,000.00	324,000.00	75.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,397,000.00	3,397,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,397,000.00	3,397,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	533,811,800.00	505,869,139.42	27,942,660.58	94.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	496,333,200.00	477,273,899.18	19,059,300.82	96.1
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	496,333,200.00	477,273,899.18	19,059,300.82	96.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,478,600.00	28,595,240.24	0.00	76.3
320001	Орон нутгийн төсвөөс	37,478,600.00	28,595,240.24	0.00	76.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	297.00	297.00	0.00	100.0

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32.00	32.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	232.00	232.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон/

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	320,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	320,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	320,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	320,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	320,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	320,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Мандал сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн баталсан төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргах болон цахим төлбөрийн баримттай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа хариуцан

гүйцэтгэж, аудитын анхан шатны чанарын хяналтыг “Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн аудитын менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар гүйцэтгэв.

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэг нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Багш бүрийг чадваржуулж, хүүхэд төлөвших орчинг бүрдүүлэх” гэж тодорхойлон, дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхэд бүрийн нас насанд тохирсон ахиц гарган баримтжуулж, тэмдэглэл хөтлөх;
- Хүүхэд бүрээс ирж буй дохио сигналыг багш мэдэрч тэдэнд тохируулан сэдэв, сургалтын төлөвлөгөө боловсруулах;
- Тухайн сэдвийн хүрээнд хүүхэд орчноосоо хөгжиж, тоглох таатай сургалтын орчинг бүрдүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор баталсан “Ковид 19” цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”;
- МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар баталсан “Цахилгаан, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан тушаал “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” журам тайланд онд шинээр мөрдөгдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 565,509.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,310.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 9,048.7 мянган төгрөгөөр төлөвлөлтийн материаллаг байдлын тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.6 хувиар буюу 39,284.0 мянган төгрөгөөр буурсан ба өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	630.3	-	(630.3)
Бараа материал	35,173.6	32,157.1	(3,016.5)
Үндсэн хөрөнгө	788,419.9	752,782.7	(35,537.2)
Нийт хөрөнгө	824,223.8	784,939.8	(39,284.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	824,223.8	784,939.8	(39,284.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	824,223.8	784,939.8	(39,284.0)

Тайлант онд НДШ-ийн 630.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,157.1 мянган төгрөг болж 3,016.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 38,969.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон аймгийн БСГ-аас 233.0 мянган төгрөгийн, сумын ЗДТГ-аас 635.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, үйл ажиллагаандаа 42,844.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 906,373.3 мянган төгрөг / анхны өртгөөр / болж 4,118.7 мянган төгрөг болсон нь төсвийн хөрөнгөөр 4,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан болон БШУЯ-наас 118.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 784,939.8 мянган төгрөг болж 39,284.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 526,225.7 мянган төгрөг болж өмнөх оноос 33,591.9 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар буурсан нь тусгай зориулалтын шилжүүлэг 29,958.6 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 4,314.2 мянган төгрөгөөр тус тус багассантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 565,509.6 мянган төгрөг болж өмнөх оноос 22,917.9 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурчээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 536,651.7 мянган төгрөгөөр тооцон, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн нийт зардал болон зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 536,651.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 12 дугаар сард хийгдсэн төсвийн өөрчлөлтөөр 2,839.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **533,811.8** мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны төсвийн хуваарьт дээд шатны байгууллагаас 3 удаа өөрчлөлт оруулжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 533,811.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 496,333.2

мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 37,478.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 496,333.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28,595.2 мянган төгрөг, нийт 524,928.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 505,869.1 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 19,059.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **505,869.1** мянган төгрөг буюу 94.7 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 2,330.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8,883.4 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 56.6 мянган төгрөгөөр, нормативт зардал 16,181.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 324.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас ариутгал, халдваргүйжүүлэх зардалд 320.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 533,811.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 505,869.1 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг 5.3 хувиар хэмнэсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад дараах байдалтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1				1	-	
Албан шаардлага	2	961.1	2	961.1	-	-	100.0
Төлбөрийн акт	1	361.5	1	361.5			100.0
Нийт	4	1,322.6	3	1,322.6	1		75.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36,924.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 5,248.5 мянган төгрөгийн алдааг залруулан, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 31,675.6 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

4.1. Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн байдлын тайлан дахь биет бус хөрөнгийн оны эхний үлдэгдэл дүн өмнөх оны аудит хийсэн тайлангийн дүнгээс 5,248.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь батлагдсан төсөв, төсвийн хэлбэлзлийн тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д: "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, **үнэн зөв**, ... илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв тайлагнах.

2 Төлбөрийн баримттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тайлант онд 24,797.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн

баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс бараа материалын 992.5 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас санхүүжүүлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

4. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Тайлант онд худалдан авсан 4,933.6 мянган төгрөгийн бараа материалыг ангилал буруу бүртгэсэн байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 4.10, 2.1.4 гэсэн заалтуудыг зөрчиж байгаа тул хөрөнгийн ангилал болон нэршлийг зөв бүртгэх.

5. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

5.1 Илрүүлэлт: Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь цалингийн зардлын дүнг НДШ-ийн тайлан дахь цалингийн зардлын дүнгээс 952.5 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

5.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2. “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, ...бүртгэж, тайлагнах” гэж заасныг зөрчиж байгаа тул санхүүгийн тайланг журам, зааврын дагуу үнэн зөв тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мандал сумын 1 дүгээр цэцэрлэг	7	36,924.1	1		-	-	1		5	36,924.1